



БАГА, СУУРЬ, БҮРЭН ДУНД БОЛОВСРОЛЫН ХИЧЭЭЛ, СУРГАЛТЫН ҮР ДҮНГ ҮНЭЛЭХ ШАЛГУУРЫГ ХЭРЭГЛЭХ ЗӨВЛӨМЖ

АНГЛИ ХЭЛ

УЛААНБААТАР 2021



БОЛОВСРОЛ,
ШИНЖЛЭХ УХААНЫ
ЯАМ



THE WORLD BANK
IBRD · IDA | WORLD BANK GROUP



ASIAN
DEVELOPMENT
BANK



БОЛОВСРОЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ ЯАМ
БОЛОВСРОЛЫН ҮНЭЛГЭЭНИЙ ТӨВ

БАГА, СУУРЬ, БҮРЭН ДУНД БОЛОВСРОЛЫН
ХИЧЭЭЛ, СУРГАЛТЫН ҮР ДҮНГ ҮНЭЛЭХ
ШАЛГУУРЫГ ХЭРЭГЛЭХ

ЗӨВЛӨМЖ

АНГЛИ ХЭЛ

АНХНЫ ХЭВЛЭЛ

УЛААНБААТАР 2021

ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Суралцагчийн үнэлгээ.....	3
---------------------------	---

БАГА, СУУРЬ, БҮРЭН ДУНД БОЛОВСРОЛЫН ТҮВШИН

НЭГ. ҮНЭЛГЭЭНИЙ ШАЛГУУРЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ЗҮЙН ЗӨВЛӨМЖ	6
1.1. Сургалтын үнэлгээний ерөнхий ойлголт	6
1.2. Гадаад хэлний судлагдахууны үнэлгээний шалгуурыг боловсруулсан арга зүй.....	7
1.3. Англи хэлний нэгж хичээлийн суралцахуйн үр дүн, үнэлгээний шалгуур.....	10
1.3.1. V ангийн “Me and my family” нэгжийн суралцахуйн үр дүн....	10
1.3.2. V ангийн “Me and my family” нэгж сэдвийн үнэлгээний шалгуур	11
1.3.3. VIII ангийн “ROUTINES” бүлэг сэдвийн үнэлгээний шалгуур.	13
1.3.4. VIII ангийн “ROUTINES” нэгж сэдвийн үнэлгээний шалгуур .	14
1.3.5. XII ангийн “TEENS TODAY” сэдвийн үнэлгээний шалгуур.....	17
1.3.6. XII ангийн “Teens today” нэгж сэдвийн үнэлгээний шалгуур.	18
1.4. Гадаад хэлний үнэлгээний шалгуурт суурилсан даалгавар боловсруулах арга зүй.....	23
1.4.1. Гадаад хэлний үнэлгээний даалгавар боловсруулах зарчим, даалгаврын төрөл, хэлбэр.....	23
1.4.2. Сонсох чадварыг илрүүлэх даалгавар боловсруулах арга, аргачлал	24
1.4.3. Ярих чадварыг илрүүлэх үнэлгээний даалгавар боловсруулах арга, аргачлал	25
1.4.4. Бичих чадварыг илрүүлэх үнэлгээний даалгавар боловсруулах арга, аргачлал	26
1.4.5. Унших чадварыг илрүүлэх даалгавар боловсруулах.....	28
ХОЁР. НЭГЖИЙН ҮНЭЛГЭЭНИЙ ЖИШИГ ДААЛГАВАР.....	29
2.1 Бага боловсролын V ангийн жишиг даалгавар (Үнэлгээний нэгж: Сонсох).....	29
2.1.1. Үнэлгээний нэгж: Сонсох	29
2.1.2. Үнэлгээний нэгж: Ярих	31

2.2. Суурь боловсролын VIII ангийн жишиг даалгавар	34
2.2.1. Үнэлгээний нэгж: Сонсох	34
2.2.2. Үнэлгээний нэгж: Ярих	37
2.2.3. Үнэлгээний нэгж: Унших	38
2.2.4. Үнэлгээний нэгж: Хэлний хэрэглээ (Use of English)	41
2.2.5. Үнэлгээний нэгж: Бичих	43
2.3. Бүрэн дунд боловсролын XII ангийн жишиг даалгавар.....	45
2.3.1. Үнэлгээний нэгж: Сонсох	45
2.3.2. Үнэлгээний нэгж: Ярих	47
2.3.3. Үнэлгээний нэгж: Унших	49
2.3.4. Үнэлгээний нэгж: Бичих	50
2.3.5. Үнэлгээний нэгж: Хэлний хэрэглээ (Use of English)	52
ГУРАВ. НОТОЛГООНД СУУРИЛСАН ШИНЖИЛГЭЭ ХИЙХ АРГАЧЛАЛ.....	55
3.1 Даалгаврын гүйцэтгэлийг нэгтгэн шинжилгээ хийх аргачлал	56
ДӨРӨВ. АНХААРАХ ЗҮЙЛ, САНАМЖ.....	61
Ном зүй	64
Нэр томъёоны орчуулга	65

СУРАЛЦАГЧИЙН ҮНЭЛГЭЭ

Боловсролын үнэлгээний нэг чухал хэсэг нь суралцагчийн үнэлгээ юм. Энэ нь суралцагчийн суралцах үйл ажиллагаа /суралцахуй/-ны талаарх мэдээлэл цуглуулах, сайжруулах, шаардлагатай тохиолдолд шийдвэр гаргах зорилгоор системтэй мэдээлэл цуглуулах, дүн шинжилгээ хийх, үнэлэлт дүгнэлт хийх үйл явц юм. Багш нар хичээл сургалтын явцад суралцагчийг үнэлж журналд дүн тавих, нэгж, бүлэг сэдвийн дараа шалгалт /сорилго¹/ авах, засаж оноожуулах /хэмжилт хийх²/, үнэлж дүгнэх³ зэрэг байнга хийдэг ажил нь үнэлгээний үйл явцад хамаарна.

Бид үнэлгээний шалгалт авах, дүн тавих үйл явцыг хийдэг боловч шалгалтаар дамжуулан суралцахуйн талаар ямар ач холбогдолтой мэдээлэл цуглуулж буй, үр дүнд шинжилгээ хийх, шинжилгээний үр дүнг сургалтын үйл ажиллагаанд бүтээлчээр хэрэглэх байдлыг орхигдуулж ирсэн. Суралцагчийн үнэлгээг зөвхөн дүн тавихын тулд хийж ирсэн тогтсон ойлголт, хандлагыг өөрчлөх хэрэгцээ байна.

Суралцагчийн үнэлгээ гэдэгт “суралцагчийн сурлагын амжилтын түвшнийг тогтоох, мэдлэг, чадвар, хандлага төлөвшлийн ахиц, өөрчлөлтийг бодитой үнэлэх, түүнд тулгарч буй бэрхшээлийг илрүүлж дэмжлэг үзүүлэх, урамшуулах үйл явц”-ыг ойлгоно.

Хичээл, сургалтын өдөр тутмын болон тодорхой хугацааны /бүлэг сэдэв, хагас жил, жилийн эцэс/ дараа хийдэг бүх төрлийн үнэлгээ “шалгуур”-т суурилсан байна.

ШАЛГУУРТ СУУРИЛСАН ҮНЭЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ШАЛГУУР

Багш нарын хувьд “үнэлгээ”-г шалгуурт суурилсан байдлаар үр дүнтэй хийхийн тулд үнэлгээний шалгуур болон шалгуурт суурилсан үнэлгээний талаарх мэдлэг ойлголтоо өргөжүүлэн гүнзгийрүүлэх шаардлагатай.

Суралцахуйн үр дүнд эзэмшвэл зохих мэдлэг, чадвар, хандлага төлөвшилд баримжаалж боловсруулсан тодорхой шалгуур (хүрэх үр дүн)-тай харьцуулж суралцагчийн сурлагын амжилтыг үнэлэх үйл явцыг шалгуурт суурилсан үнэлгээ /criterion referenced assessment/ гэдэг. Өөрөөр хэлбэл суралцагчийн гүйцэтгэлийг бусад суралцагчтай бус зөвхөн үнэлгээний шалгууртай харьцуулж үнэлж, дүгнэх үйл явц гэсэн үг.

Үнэлгээний шалгуур нь:

- Суралцахуйн үр дүнд нийцсэн сурагчийн гүйцэтгэлийг хэрхэн тодорхойлохыг зааж өгдөг.
- Сурагч суралцахуйн үр дүнг амжилттай эзэмшсэнийг харуулахын тулд юуг хийж чадаж байгаагийн товч илэрхийлэл
- Суралцахуйн үр дүн бүрийг эзэмшсэн байх тодорхой, хоёрдмол утгагүй нотолгоог бий болгох зорилготой.

¹ Сорилго нь бүх суралцагчдыг тодорхой хугацааны дараа зохион байгуулдаг, асуултын багцаас тогтсон үнэлгээний тодорхой төрөл юм. Сорилго нь тоон болон ямар нэг ангиллын хэмжээсийг ашиглан суралцагчийн нэг ба хэд хэдэн шинж чанарыг хэмжих, илэрхийлэх гэсэн системтэй арга хэрэгсэл юм.

² Хэмжилт нь сорилго, эсвэл үнэлгээний төрлийн үр дүнг тусгай дүрэм (жишээлбэл, зөв хариулыг тоолох, оноо өгөх г.м)-ийн дагуу тоогоор илэрхийлдэг. Ихэнхдээ оноо өгөх /scoring/ гэж тодорхойлдог.

³ Үнэлгээний мэдээллийг хэрэглэн, тогтсон шалгуур үзүүлэлтэд харгалзах чансааг тодорхойлох үйл явц

Өөрөөр хэлбэл, үнэлгээний шалгуур гэдэг нь сургалтын явцад суралцагч бүрийн эзэмшвэл зохих мэдлэг, чадвар, хандлага төлөвшил буюу хүрэх үр дүн юм.

Үнэлгээний шалгуур нь дараах ач холбогдолтой. Үүнд:


- Суралцагчийн сурлагын амжилтыг үнэлж, дүгнэх ижил хэмжүүрийг тодорхой, ил тод болгох.
- Үнэлгээг зөв, бодитой хийх боломж бүрдэх.
- Даалгавар боловсруулахад баримжаа болох.
- Тухайн суралцагчийн суралцахуйн давуу, сул тал, тулгамдаж буй бэрхшээлийн талаарх мэдээллийг цуглуулах.
- Суралцахуйн арга зүйг төлөвлөх, хэрэгжүүлэх замаар багшлахуйг сайжруулах боломжийг бүрдүүлэх.
- Суралцагчийг ижил шалгуураар үнэлж, тэдний ахиц амжилт, өөрчлөлтийг хянах боломж олгох.

Үнэлгээний шалгуур нь дараах шаардлагад⁴ нийцсэн байна. Үүнд:


- Боловсролын түвшин, анги, судлагдахуун бүрээр залгамж холбоотой, эрэмбэ ахисан байх
- ЕБС-ийн багш нар шууд авч ашиглах боломжтой байхаар боловсруулсан байх
- Оролцогч бүх тал /суралцагч, багш, эцэг эх, асран хамгаалагч гэх мэт/-д ойлгогдохоор товч тодорхой, оновчтой энгийн үг хэллэгээр бичсэн байх
- Давхцалгүй, нэг нэгнээсээ ялгаатай байх
- Суралцагчдад юу хийхийг тодорхой ойлгуулахуйц үйл /түлхүүр үг/ үгсийг ашигласан байх. Жишээ нь: эмхэтгэх, бий болгох, бүтээх, төлөвлөх, дахин боловсруулах, шинжлэх, дизайн хийх, сонгох, ашиглах, хэрэглэх, үзүүлэх, бэлтгэх, ашиглах, тооцоолох, тайлбарлах, урьдчилан таамаглах, харьцуулах, шүүмжлэх гэх мэт
- Сурагчийн гүйцэтгэл нь ажиглагдахуйц, хэмжигдэхүйц байхаар үг сонгох

ХИЧЭЭЛ, СУРГАЛТЫН ҮР ДҮНГ ҮНЭЛЭХ ШАЛГУУРЫН БҮТЭЦ

Ерөнхий боловсролын сургуулийн түвшинд хичээл, сургалтын үр дүнг үнэлэх шалгуурыг сургалтын хөтөлбөрийн хүрэх үр дүнд тулгуурлан дараах бүтэцтэйгээр боловсруулсан.



⁴Эх сурвалж: Боловсролын салбарын хөгжил-Боловсролын чанарт нөлөөлж буй сургуулийн хүчин зүйлс” судалгааны эцсийн тайлан, 1.14 дэх бүлэг. Азийн хөгжлийн банкны техник туслалцааны төсөл, 2017 он.



⁴Эх сурвалж: Боловсролын салбарын хөгжил-Боловсролын чанарт нөлөөлж буй сургуулийн хүчин зүйлс” судалгааны эцсийн тайлан, 1.14 дэх бүлэг. Азийн хөгжлийн банкны техник туслалцааны төсөл, 2017 он.

Нэг. Үнэлгээний шалгуурыг хэрэгжүүлэх арга зүйн зөвлөмж


1.1. СУРГАЛТЫН ҮНЭЛГЭЭНИЙ ЕРӨНХИЙ ОЙЛГОЛТ

Боловсролын чанарын асуудал нь үнэлгээтэй салшгүй холбоотой бөгөөд сурагчдын сурах хүсэл тэмүүллийг бадрааж, сурах үйл ажиллагаанд нь идэвхжүүлж суралцахуй, багшийн заах арга зүйг сайжруулахад оршино. Сургалтын төлөвлөгөө, сургалтын хөтөлбөрийн хэрэгжилт, шинэчлэн сайжруулахад хэрэгцээтэй мэдээллийг тодорхойлох, олж авах, хангах үйл явцыг үнэлгээ гэнэ. /Source: Kemmis, 1989, p.117/.

Суралцагчийн үнэлгээ гэдэгт сурлагын амжилтын түвшинг тогтоох, мэдлэг, чадвар, хандлага төлөвшлийн ахиц, өөрчлөлтийг бодитой үнэлэх тэдэнд тулгарч буй бэрхшээлийг илрүүлж дэмжлэг үзүүлэх, урамшуулах үйл явцыг ойлгоно. Суралцагчийн үнэлгээ нь тухайн сургалтын хөтөлбөрийн хүрээнд эзэмшвэл зохих мэдлэг, чадвар, хандлага төлөвшил буюу хүрэх үр дүнг тодорхойлсон “шалгуур”- т суурилсан байна.

Шалгуурт суурилсан үнэлгээний зорилт нь сургалтын хөтөлбөрийн суралцахуйн зорилтод үндэслэсэн байна. *Шалгуурт суурилсан үнэлгээ* нь суралцагчийн гүйцэтгэлийг бусад суралцагчийн гүйцэтгэлтэй бус зөвхөн өөрийн өмнөх гүйцэтгэлтэй харьцуулж үнэлэн дүгнэх юм. Ерөнхий боловсролын сургуульд одоогоор шалгуурт суурилсан гурван төрлийн үнэлгээг ашиглаж байна.

Зураг 1.



Суралцагчдыг оношлох, явцын ба үр дүнгийн үнэлгээгээр үнэлнэ.

- Оношлох үнэлгээ (**Diagnostic Assessment**) нь сурах үйл ажиллагаанд тулгарч байгаа бэрхшээл, түүний шалтгааныг тодорхойлох зорилгоор хичээлийн жил, хагас жил, улирал, бүлэг сэдвийн эхэнд сурагчийн мэдлэг, чадвар, хандлагын түвшинг тандаж илрүүлэхэд чиглэнэ.
- Явцын үнэлгээ (**Formative assessment**) нь сурагчийн ахиц, хөгжлийн талаар мэдээлэл цуглуулах, суралцахуйг дэмжих, сайжруулах зорилгоор хичээл сургалтын явцад тогтмол хийгдэж, багш, сурагч, эцэг эхэд мэдээлэл өгөх, эргэх холбоо бий болгоход чиглэнэ.
- Үр дүнгийн үнэлгээ (**Summative assessment**) нь сурагчийн тухайн хичээлийн жил, хагас жил, бүлэг сэдвийн хүрээнд эзэмшсэн мэдлэг, чадварын түвшинг тогтоох, хандлага төлөвшилд үнэлэлт, дүгнэлт өгөхөд чиглэнэ. Анги дэвших болон төгсөх шалгалтаар сургалтын хөтөлбөрийн үнэлгээний зорилт, шалгуур, жинг үндэслэн үр дүнгийн үнэлгээ хийнэ.

1.2 ГАДААД ХЭЛНИЙ СУДЛАГДАХУУНЫ ҮНЭЛГЭЭНИЙ ШАЛГУУРЫГ БОЛОВСРУУЛСАН АРГА ЗҮЙ


Аливаа гадаад хэлний сургалт нь суралцагчдыг хэлэхүйн дөрвөн чадварт (сонсох, ярих, унших, бичих) сургах зорилго тавьдаг тул тэдгээрийг судлагдахууны үнэлгээний нэгжээр сонгон тодорхойлсон. Үнэлгээний нэгж нь нэгж хичээлээс ялгаатай. Үнэлгээний нэгж нь тухайн агуулгын хувьд сурагчдын эзэмшсэн мэдлэг, чадварыг илрүүлэн дүгнэх шалгуурыг нэгтгэсэн нэгж бол, нэгж хичээл нь сургалтын хөтөлбөрийн агуулгыг томсгон дидактик нэгжид хуваасан шийдэл бүхий агуулгын хуваарилалт юм.

✓ Үнэлгээний нэгж

Үнэлгээний нэгж гэдгийг тухайн ангийн агуулгын хувьд суралцагчдын эзэмшсэн мэдлэг, чадварыг илрүүлэн дүгнэх шалгуурын нэгтгэл гэж ойлгож болно.

Дараах схемээс суралцахуйн үр дүнгийн үнэлгээний шалгуурыг гаргасан дарааллыг харж болно.

Зураг 2.



Сургалтын хөтөлбөрт тусгагдсан суралцахуйн зорилтуудыг багцлан нэгжийг тогтоож, суралцахуйн үр дүнг тодорхойлсон. Суралцахуйн үр дүн гэдэг нь тухайн суралцагч хөтөлбөрийг судалсны эцэст юу мэддэг, чаддаг болсон байхыг харуулсан илэрхийлэл юм. Суралцахуйн үр дүнгээс үнэлгээний шалгуурыг боловсруулсан болно. Үнэлгээний шалгуур нь стандартын шаардлагыг хангаж, сургалтын үр дүнд хүрсэн байдлыг харуулахын тулд цуглуулсан нотолгоо юм. Өөрөөр хэлбэл, суралцахуйн үр дүнг үнэлэх шалгуур нь суралцахуйн үр дүнд хүрсэн үү? юу хийж чадвал үр дүнд хүрсэн гэх вэ? гэдгийг харуулна. ГҮЙЦЭТГЭЛИЙН ТҮВШИН нь суралцагч юуг яаж хийх ёстой вэ? гэдгийг харуулах үзүүлэлт юм.

✓ **Суралцахуйн үр дүн :**

Суралцахуйн үр дүн гэдэг нь тухайн хичээл, хөтөлбөрийг судалсны эцэст сурагчид юу мэддэг, чаддаг болсон байхыг тодорхойлсон тусгай илэрхийлэл юм.

Англи хэл судлагдахууны үнэлгээний шалгуурыг боловсруулахдаа V-XII анги тус бүрийн сургалтын хөтөлбөрийн агуулга болох суралцахуйн зорилтыг багцалж, сонсох, ярих, унших, бичих, хэлний хэрэглээний 5 нэгж болгон нэгтгэж, нэгж тус бүрээр суралцахуйн 5 үр дүнг тодорхойлсон. Суралцахуйн үр дүн тус бүрээс үнэлгээний шалгуурыг гаргаж, шалгуур тус бүрийг 4 түвшнээр ангилж боловсруулсан болно. Анги тус бүрээр боловсруулсан англи хэл судлагдахууны үнэлгээний шалгуурын тоон үзүүлэлтийг харуулбал:

Хүснэгт 1: Англи хэлний судлагдахууны үнэлгээний шалгуурын тоо

Анги	Суралцахуйн зорилтын тоо	Суралцахуйн үр дүнгийн тоо					Суралцахуйн үр дүнгээс гаргасан шалгуурын тоо				
		L	S	R	W	UE	L	S	R	W	UE
5	37	1	1			1	2	2			1
6	43	1	1	1	1	1	2	2	2	2	2
7	50	1	1	1	1	1	2	2	2	2	2
8	50	1	1	1	1	1	2	2	2	2	2
9	50	1	1	1	1	1	2	2	2	2	2
10 (Заавал)	50	1	1	1	1	1	2	2	2	2	2
10 (Сонгон)	50	1	1	1	1	1	2	2	2	2	2
11 (Заавал)	50	1	1	1	1	1	2	2	2	2	2
11 (Сонгон)	50	1	1	1	1	1	2	2	2	2	2
12 (Заавал)	50	1	1	1	1	1	2	2	2	2	2
12 (Сонгон)	50	1	1	1	1	1	2	2	2	2	2
Нийт	530	11	11	10	10	11	22	22	20	20	19
Нийт		53					103				

✓ **Үнэлгээний шалгуур, гүйцэтгэлийн үзүүлэлт**

Үнэлгээний шалгуур нь суралцагчийн ажлыг хэмжих жишиг стандартын цогц бөгөөд суралцагч суралцахуйн үр дүнд хүрсэн үү, үр дүнд хүрэхийн тулд юу хийж чаддаг болсон байх вэ? гэдгийг илэрхийлнэ. Үнэлгээний шалгуурт юуг, хэрхэн, яаж үнэлэхийг тусгасан байдаг.

Сургалтын хөтөлбөрийн хүрээнд тодорхойлсон агуулгын хүрээг, үнэлгээний шалгуурт тодорхойлсон агуулгын хүрээг (**content framework**) хэлний түвшин бүрээр ерөнхийлэн харуулбал анги ахих тутам агуулгын хүрээ өсөн нэмэгдэж байна.

Хүснэгт 2

Анги	Хэлний түвшин	Судлах агуулгын хүрээ	Шалгуур дахь агуулгын хүрээ
5	Towards low A1	өдөр тутмын хязгаарлагдмал сэдвийн хүрээ	судалсан өдөр тутмын сэдвийн хязгаарлагдмал хүрээ
6	Low A1	өдөр тутмын тодорхой сэдвийн хүрээ	судалсан өдөр тутмын тодорхой сэдвийн хүрээ
7	Mid A1	өдөр тутмын тодорхой, танил сэдвийн хүрээ	судалсан өдөр тутмын тодорхой, танил сэдвийн хүрээ
8	High A1	өдөр тутмын амьдрал ахуй, нийгэм соёлын харилцааны танил сэдвийн хүрээ	судалсан танил сэдвийн хүрээ
9	Low A2	ахуй амьдрал, нийгэм соёл, шинжлэх ухааны танил бус сэдвийн хүрээ	судалсан ерөнхий сэдвийн хүрээ
10	Mid A2	ахуй амьдрал, нийгэм соёл, шинжлэх ухааны танил бус сэдвийн хүрээ	судалсан танил бус сэдвийн хүрээ
11	High A2	ахуй амьдрал, нийгэм соёл, шинжлэх ухааны өргөн сэдвийн хүрээ	судалсан сэдвийн өргөн хүрээ
12	Low B1	ахуй амьдрал, нийгэм соёл, шинжлэх ухааны дэлгэрэнгүй сэдвийн хүрээ	судалсан дэлгэрэнгүй сэдвийн өргөн хүрээ

Гадаад хэлний сургалтын хөтөлбөр дэх агуулга дараах сэдвийн хүрээнд тодорхойлогдоно.

Зураг 3.



Эдгээр сэдвийг анги бүрт нарийвчлан спираль хэлбэрээр, хөнгөнөөс хүнд рүү гүнзгийрүүлэн судлахаар сургалтын хөтөлбөр, сурах бичигт тусгасан.

Жишээ нь: A1 түвшний хувьд өдөр тутмын амьдрал гэсэн сэдэв нь

- Би
- Гэр бүл
- Найз нөхөд
- Сургууль
- Оршин суудаг газар

- Эргэн тойрны газар нутаг
- Өдрийн дэглэм
- Чөлөөт цаг
- Сонирхдог зүйл
- Цаг агаар
- Эрүүл мэнд гэх мэт дэд сэдвийг багтаадаг.

A1 түвшний сурагчид эдгээр сэдвийн хүрээнд харилцахдаа энгийн, хялбар, цөөн хэдэн үг, өгүүлбэр ашиглан харилцах, энгийн асуулт асуух ба хариулах мөн судалсан сэдвийн хүрээнд хялбар, үгийн тоо багтаамж нь түвшинд тохирсон эх сонсох ба унших юм. Мөн анги, түвшинд тохирсон (40-80) үгийн хооронд эх бичих гэх мэтээр үгийн тоог зааж өгч болно.

Гадаад хэл судлахад дээр дурдсан сэдвийн хүрээ нь анги бүрт тодорхой хэмжээгээр давтагдан ордог бөгөөд өөрөөр хэлбэл A2 түвшний хувьд сонсох, ярих, унших, бичих чадварууд болон үгийн нөөц, хэлний хэрэглээ нь агуулга, тоо ба чанарын хувьд өмнөх түвшнээс илүү байна гэсэн үг юм. Иймд A1, A2 ба Low B1 түвшинд сонсох, ярих, унших, бичих үгийн нөөц, хэлний хэрэглээг тодорхойлсон суралцахуйн зорилтууд дээр дурдсанчилан тоо ба чанарын ялгаатай байх бөгөөд тэдгээр ялгааг СҮД-г (суралцахуйн үр дүн) тодорхойлохдоо хязгаарлагдмал, (**limited**) танил, (**familiar**) танил бус, (**unfamiliar**) тодорхой, (**some**) өргөн, (**wide**) дэлгэрэнгүй (**extended**) сэдвийн хүрээ (**range**) гэж ялгасан болно. Үүнтэй уялдан СҮД-ийн шалгуурыг тодорхойлохдоо тухайн судалсан сэдвийн хүрээнд аль хэр хэмжээнд хүрсэн байхыг мөн сэдвийн хүрээ (**range**) ойлголтоор илэрхийлсэн болно.

1.3. АНГЛИ ХЭЛНИЙ НЭГЖ ХИЧЭЭЛИЙН СУРАЛЦАХУЙН ҮР ДҮН, ҮНЭЛГЭЭНИЙ ШАЛГУУР

1.3.1. V ангийн “Me and my family” нэгжийн суралцахуйн үр дүн

V ангийн нэгж хичээл дээр үнэлгээний нэгж дээр суурилсан суралцахуйн үр дүнг хэрхэн боловсруулж болох аргачлалыг харуулбал:

V АНГИЙН “ME AND MY FAMILY” СЭДВИЙН ҮНЭЛГЭЭ

Хүснэгт 3. V ангийн “Me and my family” сэдвийн үнэлгээний нэгжийн суралцахуйн үр дүнг тодорхойлсон аргачлал

Суралцахуйн зорилт	Үнэлгээний нэгж	Суралцахуйн үр дүн
5.L3 5.L4 5.L5 5.L7	Сонсох	Сурагч нь “Me and my family” сэдвийн хүрээнд сонсох зааварчилгаа болон өөрийгөө болон гэр бүлээ танилцуулах энгийн, богино ярианы гол ба туслах санааг дэмжлэгтэйгээр сонсоод ялган таньдаг болно.
5.S1 5.S2 5.S6 5.S7	Ярих	Сурагч нь “Me and my family” сэдвийн хүрээнд энгийн үг хэллэг, богино өгүүлбэр ашиглан гэр бүлийн гишүүдийг заасан үг хэллэг, богино өгүүлбэрийг дэмжлэгтэйгээр нэрлэн хэлдэг болно.
5.UЕ5 5.UЕ6 5.UЕ7	Хэлний хэрэглээ	Сурагч нь “Me and my family” сэдвийн хүрээнд үг, хэл зүйн хэрэглээний мэдлэгээ харилцан яриандаа дэмжлэгтэйгээр ашигладаг болно.

1.3.2. V ангийн “Me and my family” нэгж сэдвийн үнэлгээний шалгуур

Хүснэгт 4. “Me and my family” сэдвийн үнэлгээний нэгжийн суралцахуйн үр дүнгийн үнэлгээний шалгуурыг тодорхойлсон аргачлал

Үнэлгээний нэгж	Суралцахуйн үр дүн	Суралцахуйн үр дүнгийн үнэлгээний шалгуур
Сонсох	Сурагч нь “Me and my family” сэдвийн хүрээнд сонсох зааварчилгаа болон өөрийгөө, гэр бүлээ танилцуулах энгийн, богино яриа, хүүрнэлийн гол ба туслах санааг дэмжлэгтэйгээр сонсоод ялган таньдаг болно.	Судалсан “Me and my family” сэдвийн хүрээнд сонсох энгийн зааварчилгааг дэмжлэгтэйгээр сонсоод ялган таньдаг
		Судалсан “Me and my family” сэдвийн хүрээнд өөрийгөө болон гэр бүлээ танилцуулах энгийн, богино ярианы гол ба туслах санааг дэмжлэгтэйгээр сонсоод ялган таньдаг
Ярих	Сурагч нь “Me and my family” сэдвийн хүрээнд энгийн үг хэллэг, богино өгүүлбэр ашиглан гэр бүлийн гишүүдийг заасан үг хэллэг, богино өгүүлбэрийг дэмжлэгтэйгээр нэрлэн хэлдэг болно.	Судалсан “Me and my family” сэдвийн хүрээнд гэр бүлийн гишүүдийг заасан үг хэллэг, богино өгүүлбэр ашиглан илэрхийлдэг
		Судалсан “Me and my family” сэдвийн хүрээнд гэр бүлийн талаар энгийн асуулт асуудаг, хос, бүлэг, ангиар ажиллахад энгийн үг, хэллэг, богино өгүүлбэр ашиглан товч дүрслэн ярих ба харилцан ярилцдаг
Хэлний хэрэглээ	Сурагч нь “Me and my family” сэдвийн хүрээнд үг, хэл зүйн хэрэглээний мэдлэгээ харилцан яриандаа дэмжлэгтэйгээр ашигладаг болно.	Судалсан “Me and my family” сэдвийн хүрээнд <i>Wh questions, demonstrative pronouns this, that, these, have got + noun</i> хэл зүйн хэрэглээний мэдлэгээ өөрийнхөө болон гэр бүлийн тухай харилцан яриандаа дэмжлэгтэйгээр ашигладаг

Хүснэгт 5. “ME AND MY FAMILY” бүлэг сэдвийн жишээн дээр суралцахуйн үр дүнгийн шалгуурын ГҮЙЦЭТГЭЛИЙН ТҮВШИНг багцлан (I, II, III, IV) 4 түвшинд рубрикээр харуулав.

Суралцахуйн үр дүнгийн үнэлгээний шалгуур	ГҮЙЦЭТГЭЛИЙН ТҮВШИН			
	I	II	III	IV
<u>СОНСОХ</u> 1. Судалсан “Me and my family” сэдвийн хүрээнд сонсох энгийн зааварчилгааг дэмжлэгтэйгээр сонсоод ялган таньдаг	Судалсан “Me and my family” сэдвийн хүрээнд ангид хэрэглэгдэх энгийн богино, зааварчилгааг дэмжлэгтэйгээр сонсоод цөөн тохиолдолд ялган таньдаг	Судалсан “Me and my family” сэдвийн хүрээнд ангид хэрэглэгдэх энгийн богино, зааварчилгааг дэмжлэгтэйгээр сонсоод зарим тохиолдолд ялган таньдаг	Судалсан “Me and my family” сэдвийн хүрээнд ангид хэрэглэгдэх энгийн богино, зааварчилгааг дэмжлэгтэйгээр сонсоод ихэнх тохиолдолд ялган таньдаг	Судалсан “Me and my family” сэдвийн хүрээнд ангид хэрэглэгдэх энгийн богино, зааварчилгааг дэмжлэгтэйгээр сонсоод бүх тохиолдолд ялган таньдаг

<p><u>СОНСОХ</u></p> <p>2. Судалсан “Me and my family” сэдвийн хүрээнд өөрийгөө болон гэр бүлээ танилцуулах энгийн, богино ярианы гол ба туслах санааг дэмжлэгтэйгээр сонсоод ялган таньдаг</p>	<p>Судалсан “Me and my family” сэдвийн хүрээнд хувийн мэдээллийн талаарх энгийн яриаг дэмжлэгтэйгээр сонсоод гол ба туслах санааг цөөн тохиолдолд ялган таньдаг</p>	<p>Судалсан “Me and my family” сэдвийн хүрээнд хувийн мэдээллийн талаарх энгийн яриаг дэмжлэгтэйгээр сонсоод гол ба туслах санааг зарим тохиолдолд ялган таньдаг</p>	<p>Судалсан “Me and my family” сэдвийн хүрээнд хувийн мэдээллийн талаарх энгийн яриаг дэмжлэгтэйгээр сонсоод гол ба туслах санааг ихэнх тохиолдолд ялган таньдаг</p>	<p>Судалсан “Me and my family” сэдвийн хүрээнд хувийн мэдээллийн талаарх энгийн яриаг дэмжлэгтэйгээр сонсоод гол ба туслах санааг бүхий л тохиолдолд ялган таньдаг</p>
<p><u>ЯРИХ</u></p> <p>1. Судалсан “Me and my family” сэдвийн хүрээнд гэр бүлийн гишүүдийг заасан үг хэллэг, богино өгүүлбэр ашиглан илэрхийлдэг</p>	<p>Судалсан “Me and my family” сэдвийн хүрээнд хувийн мэдээллийг энгийн үг ашиглан илэрхийлдэг</p>	<p>Судалсан “Me and my family” сэдвийн хүрээнд хувийн мэдээллийг энгийн үг хэллэг ашиглан ойлгосноо илэрхийлдэг</p>	<p>Судалсан “Me and my family” сэдвийн хүрээнд хувийн мэдээллийг 6-8 хүртэлх үг хэллэг ашиглан илэрхийлдэг</p>	<p>Судалсан “Me and my family” сэдвийн хүрээнд хувийн мэдээллийг 9-10 хүртэлх үг хэллэг ашиглан илэрхийлдэг</p>
<p><u>ЯРИХ</u></p> <p>2. Судалсан “Me and my family” сэдвийн хүрээнд гэр бүлийн талаар энгийн асуулт асуудаг, хос, бүлэг, ангиар ажиллахад энгийн үг, хэллэг, богино өгүүлбэр ашиглан товч дүрслэн ярих ба харилцан ярилцдаг.</p>	<p>Судалсан “Me and my family” сэдвийн хүрээнд ерөнхий мэдээллийн талаар энгийн асуулт асуудаг, хос, бүлэг, ангиар ажиллахад энгийн үг, хэллэг, богино өгүүлбэр ашиглан маш цөөн тохиолдолд дүрслэн ярих болон харилцан ярилцахыг оролддог</p>	<p>Судалсан “Me and my family” сэдвийн хүрээнд ерөнхий мэдээллийн талаар энгийн асуулт асуудаг, хос, бүлэг, ангиар ажиллахад энгийн үг, хэллэг, богино өгүүлбэр ашиглан зарим тохиолдолд дүрслэн товч ярьдаг, харилцан ярилцдаг</p>	<p>Судалсан “Me and my family” сэдвийн хүрээнд ерөнхий мэдээллийн талаар энгийн асуулт асуудаг, хос, бүлэг, ангиар ажиллахад энгийн үг, хэллэг, богино өгүүлбэр ашиглан ихэнх тохиолдолд товч тодорхой дүрслэн ярьдаг, харилцан ярилцдаг</p>	<p>Судалсан “Me and my family” сэдвийн хүрээнд ерөнхий мэдээллийн талаар энгийн асуулт асуудаг, хос, бүлэг, ангиар ажиллахад энгийн үг, хэллэг, богино өгүүлбэр ашиглан товч дүрслэн ярих ба харилцан ярилцдаг.</p>
<p><u>ХЭЛНИЙ ХЭРЭГЛЭЭ</u></p> <p>Судалсан “Me and my family” сэдвийн хүрээнд Wh questions, demonstrative pronouns this, that, these, have got + noun хэл зүйн хэрэглээний мэдлэгээ өөрийнхөө болон гэр бүлийн тухай харилцан яриандаа дэмжлэгтэйгээр ашигладаг.</p>	<p>Судалсан “Me and my family” сэдвийн хүрээнд хэл зүйн хэрэглээний мэдлэгээ өдөр тутмын харилцан яриандаа ихэнх тохиолдолд дэмжлэгтэйгээр хэрэглэдэг</p>	<p>Судалсан “Me and my family” сэдвийн хүрээнд хэл зүйн хэрэглээний мэдлэгээ өдөр тутмын харилцан яриандаа зарим үед дэмжлэгтэйгээр хэрэглэдэг</p>	<p>Судалсан “Me and my family” сэдвийн хүрээнд хэл зүйн хэрэглээний мэдлэгээ өдөр тутмын харилцан яриандаа бага зэрэг дэмжлэгтэйгээр хэрэглэдэг</p>	<p>Судалсан “Me and my family” сэдвийн хүрээнд хэл зүйн хэрэглээний мэдлэгээ өдөр тутмын харилцан яриандаа бага зэргийн дэмжлэгтэйгээр алдаагүй зөв хэрэглэдэг</p>

1.3.3. VIII ангийн “ROUTINES” бүлэг сэдвийн үнэлгээний шалгуур**VIII АНГИЙН “ROUTINES” НЭГЖИЙН СУРАЛЦАХУЙН ҮР ДҮН**

VIII ангийн нэгж хичээл дээр үнэлгээний нэгж дээр суурилсан суралцахуйн үр дүнг хэрхэн боловсруулж болох аргачлалыг харуулбал:

VIII АНГИЙН “ROUTINES” СЭДВИЙН ҮНЭЛГЭЭ

Хүснэгт 6. VIII ангийн “Routines” сэдвийн үнэлгээний нэгжийн суралцахуйн үр дүнг тодорхойлсон аргачлал

Суралцахуйн зорилт	Үнэлгээний нэгж	Суралцахуйн үр дүн
8.L2 8.L4 8.L5 8.L9	Сонсох	Сурагч нь “Routines” сэдвийн хүрээнд ангид хэрэглэх нийлмэл зааварчилгааны дэс дараалал, энгийн яриа хүүрнэл, гол, туслах болон хэд хэдэн санааг сонсоод ялган таньдаг болно.
8.S1 8.S2 8.S3 8.S5 8.S6 8.S7	Ярих	Сурагч нь “Routines” сэдвийн хүрээнд хувийн ерөнхий мэдээлэл болон үйл явдлыг дэлгэрэнгүй илэрхийлэх замаар бусадтай харилцахдаа үг хэллэг, энгийн холбоос бүхий өгүүлбэрээр санаа бодлоо илэрхийлдэг болно.
8.R4 8.R5	Унших	Сурагч нь “Routines” сэдвийн хүрээнд эхийн үгийг зөв дуудах, энгийн эхийн хам сэдвээс гол, туслах, дагалдах утга санааг ялган таньдаг болно.
8.W2 8.W4 8.W6 8.W7 8.W8	Бичих	Сурагч нь “Routines” сэдвийн хүрээнд үгсийг зөв бичих, энгийн өгүүлбэр, богино эхийг үгсийг зөв бичих, энгийн ба энгийн нийлмэл өгүүлбэр, богино эх зохион бичдэг болно. зохион бичдэг, бичих зүйлээ төлөвлөдөг болно.
8.UЕ1 8.UЕ4 8.UЕ5 8.UЕ6 8.UЕ9 8.UЕ11	Хэлний хэрэглээ	Сурагч нь “Routines” сэдвийн хүрээнд хэл зүйн хэрэглээний мэдлэгээ аман болон бичгийн харилцаанд ашигладаг болно.

1.3.4. VIII ангийн “ROUTINES” нэгж сэдвийн үнэлгээний шалгуур

Хүснэгт 7. “Routines” нэгж сэдвийн үнэлгээний нэгжийн суралцахуйн үр дүнгийн үнэлгээний шалгуурыг тодорхойлсон аргачлал

Үнэлгээний нэгж	Суралцахуйн үр дүн	Суралцахуйн үр дүнгийн үнэлгээний шалгуур
Сонсох	Сурагч нь “Routines” сэдвийн хүрээнд ангид хэрэглэх нийлмэл зааварчилгааны дэс дараалал, энгийн яриа хүүрнэл, гол, туслах болон хэд хэдэн санааг сонсоод ялган таньдаг болно.	Судалсан танил сэдвийн хүрээнд ангид хэрэглэх дэлгэрэнгүй зааварчилгааны дэс дарааллыг сонсоод ялган таньдаг
		Судалсан тодорхой ба танил сэдвийн хүрээнд хувийн мэдээллийг лавлах энгийн асуулт, энгийн яриа, хүүрнэлээс гол ба туслах санаа, хам сэдвийн утга, агуулга, өгүүлэгчийн санаа бодлыг сонсоод ойлгодог
Ярих	Сурагч нь “Routines” сэдвийн хүрээнд хувийн ерөнхий мэдээлэл болон үйл явдлыг дэлгэрэнгүй илэрхийлэх замаар бусадтай харилцахдаа үг хэллэг, энгийн холбоос бүхий өгүүлбэрээр санаа бодлоо илэрхийлдэг болно.	Судалсан танил сэдвийн хүрээнд хувийн дэлгэрэнгүй мэдээллийг өгүүлбэрийн түвшинд илэрхийлэх замаар ерөнхий мэдээллийн талаар асуулт асууж, хариулдаг
		Судалсан танил сэдвийн хүрээнд хос, бүлэг, ангиар ажиллан бусадтай харилцахдаа судалсан үгийн нөөц, энгийн үг хэллэг, холбоос ашиглан өөрийн санаа бодлыг илэрхийлдэг
Унших	Сурагч нь “Routines” сэдвийн хүрээнд эхийн үгийг зөв дуудах, энгийн эхийн хам сэдвээс гол, туслах, дагалдах утга санааг ялган таньдаг болно.	Судалсан танил сэдвийн хүрээнд эхийн үгийг зөв дуудан уншдаг
		Судалсан танил сэдвийн хүрээнд энгийн эхийн хам сэдвээс гол ба туслах санаа, зохиогчийн хандлага, санаа бодлыг уншаад ялган таньдаг
Бичих	Сурагч нь “Routines” сэдвийн хүрээнд үгсийг зөв бичих, энгийн өгүүлбэр, богино эхийг үгсийг зөв бичих, энгийн ба энгийн нийлмэл өгүүлбэр, богино эх зохион бичдэг болно. зохион бичдэг, бичих зүйлээ төлөвлөдөг болно.	Судалсан танил сэдвийн хүрээнд үгсийг зөв бичдэг, цэг тэмдэгийг зориулалтын дагуу хэрэглэдэг
		Судалсан танил сэдвийн хүрээнд зэрэгцүүлэн холбох холбоосыг ашиглан энгийн нийлмэл өгүүлбэр бичдэг ба бичих зүйлээ төлөвлөдөг, хянадаг
Хэлний хэрэглээ	Сурагч нь “Routines” сэдвийн хүрээнд хэл зүйн хэрэглээний мэдлэгээ аман болон бичгийн харилцаанд ашигладаг болно.	Судалсан танил сэдвийн хүрээнд хэлзүйн мэдлэгээ ярих болон бичихдээ ялган таньдаг
		Судалсан танил сэдвийн хүрээнд идэвхтэй үгийн нөөцийг аман болон бичгийн харилцаанд ашигладаг

Хүснэгт 8. “ROUTINES” нэгж сэдвийн жишээн дээр суралцахуйн үр дүнгийн шалгуурын ГҮЙЦЭТГЭЛИЙН ТҮВШИНг багцлан (I, II, III, IV) 4 түвшинд рубрикээр харуулав.

Суралцахуйн үр дүнгийн үнэлгээний шалгуур	ГҮЙЦЭТГЭЛИЙН ТҮВШИН			
	I	II	III	IV
<p><u>СОНСОХ</u></p> <p>1. Судалсан танил сэдвийн хүрээнд ангид хэрэглэх дэлгэрэнгүй зааварчилгааны дэс дарааллыг сонсоод ялган таньдаг</p>	<p>Судалсан “Routines” сэдвийн хүрээнд ангид хэрэглэх дэлгэрэнгүй зааварчилгааны дэс дарааллыг анхааран сонсдог</p>	<p>Судалсан “Routines” сэдвийн хүрээнд ангид хэрэглэх дэлгэрэнгүй зааварчилгааны дэс дарааллыг сонсоод гүйцэтгэхийг хичээдэг</p>	<p>Судалсан “Routines” сэдвийн хүрээнд ангид хэрэглэх дэлгэрэнгүй зааварчилгааны дэс дарааллыг сонсож ойлгосноо бүрэн илэрхийлдэг</p>	<p>Судалсан “Routines” сэдвийн хүрээнд ангид хэрэглэх дэлгэрэнгүй зааварчилгааны дэс дарааллыг сонсож ойлгосноо бүрэн илэрхийлдэг</p>
<p><u>СОНСОХ</u></p> <p>2. Судалсан тодорхой ба танил сэдвийн хүрээнд хувийн мэдээллийг лавлах энгийн асуулт, энгийн яриа, хүүрнэлээс гол ба туслах санаа, хам сэдвийн утга, агуулга, өгүүлэгчийн санаа бодлыг сонсоод ойлгодог</p>	<p>Судалсан “Routines” сэдвийн хүрээнд хувийн мэдээллийг лавлах энгийн асуулт, энгийн яриа, хүүрнэлээс гол ба туслах санааг анхааран сонсож ойлгохыг хичээдэг</p>	<p>Судалсан “Routines” сэдвийн хүрээнд хувийн мэдээллийг лавлах энгийн асуулт, энгийн яриа, хүүрнэлээс зарим тохиолдолд гол ба туслах санаа, хам сэдвийн утга, агуулга, өгүүлэгчийн зарим санааг ойлгож, ойлгосноо үг хэллэг, богино өгүүлбэрээр илэрхийлдэг</p>	<p>Судалсан “Routines” сэдвийн хүрээнд хувийн мэдээллийг лавлах энгийн асуулт, энгийн яриа, хүүрнэлээс зарим гол ба туслах санаа, хам сэдвийн утга, агуулга, өгүүлэгчийн санаа бодлыг сонсоод ойлгосноо үг хэллэг, өгүүлбэрээр илэрхийлдэг</p>	<p>Судалсан “Routines” сэдвийн хүрээнд хувийн мэдээллийг лавлах энгийн асуулт, энгийн яриа, хүүрнэлээс гол ба туслах санаа, хам сэдвийн утга, агуулга, өгүүлэгчийн санаа бодлыг сонсоод бүрэн ойлгож, ойлгосноо амаар болон бичгээр хэд хэдэн өгүүлбэрийн түвшинд илэрхийлдэг</p>
<p><u>ЯРИХ</u></p> <p>1. Судалсан танил сэдвийн хүрээнд хувийн дэлгэрэнгүй мэдээллийг өгүүлбэрийн түвшинд илэрхийлэх замаар ерөнхий мэдээллийн талаар асуулт асууж, хариулдаг</p>	<p>Судалсан “Routines” сэдвийн хүрээнд хувийн мэдээллийг өгүүлбэрийн түвшинд дэмжлэгтэйгээр илэрхийлэхийг оролддог, ерөнхий мэдээллийн талаар асуултыг ялган таньдаг ба асуултад дэмжлэгтэйгээр хариулдаг</p>	<p>Судалсан “Routines” сэдвийн хүрээнд хувийн мэдээллийг өгүүлбэрийн түвшинд заримдаа дэмжлэггүйгээр илэрхийлдэг ба ерөнхий мэдээллийн талаар энгийн асуулт асуух ба асуултад энгийн үг хэллэг, богино өгүүлбэрээр хариулдаг</p>	<p>Судалсан “Routines” сэдвийн хүрээнд хувийн дэлгэрэнгүй мэдээллийг өгүүлбэрийн түвшинд ихэнхдээ дэмжлэггүйгээр илэрхийлэх ба ерөнхий мэдээллийн талаар зарим нэгэн асуултыг асуудаг ба асуултад өгүүлбэрээр хариулдаг</p>	<p>Судалсан “Routines” сэдвийн хүрээнд хувийн дэлгэрэнгүй мэдээллийг өгүүлбэрийн түвшинд бүрэн ойлгосноо дэмжлэггүйгээр илэрхийлэх, ерөнхий мэдээллийн талаар бусдаас оновчтой асуулт асуудаг, бусдын яриаг нэгтгэн дүгнэдэг ба асуултад ойлгомжтой хариулдаг</p>

<p><u>ЯРИХ</u></p> <p>2. Судалсан танил сэдвийн хүрээнд хос, бүлэг, ангиар ажиллан бусадтай харилцахдаа судалсан үгийн нөөц, энгийн үг хэллэг, холбоос ашиглан өөрийн санаа бодлыг илэрхийлдэг</p>	<p>Судалсан “Routines” сэдвийн хүрээнд хос, бүлэг, ангиар ажиллан, бусадтай харилцахдаа болон өөрийн санаагаа илэрхийлэхдээ бусдын дэмжлэг авдаг</p>	<p>Судалсан “Routines” сэдвийн хүрээнд хос, бүлэг, ангиар ажиллан, бусадтай харилцахдаа энгийн үг хэллэг, зарим нэгэн холбоосыг ашиглан ойлгосноо болон өөрийн санаа бодлыг илэрхийлэх ба зарим үед дэмжлэг шаарддаг</p>	<p>Судалсан “Routines” сэдвийн хүрээнд хос, бүлэг, ангиар ажиллан, бусадтай харилцахдаа судалсан үгийн нөөц, энгийн үг хэллэг, холбоос ашиглан өөрийн санаа бодлыг ихэнх тохиолдолд зөв илэрхийлдэг</p>	<p>Судалсан “Routines” сэдвийн хүрээнд хос, бүлэг, ангиар ажиллан, бусадтай харилцахдаа судалсан үгийн нөөц, энгийн үг хэллэг, холбоос ашиглан өөрийн санаа бодлыг оновчтой зөв илэрхийлдэг</p>
<p><u>УНШИХ</u></p> <p>Судалсан танил сэдвийн хүрээнд эхийн үгийг зөв дуудан уншдаг</p>	<p>Судалсан “Routines” сэдвийн хүрээнд эхийн үг болон авиа, гийгүүлэгчийн нийлэмжүүд, үгийн өргөлтийг дэмжлэгтэйгээр зөв уншдаг</p>	<p>Судалсан “Routines” сэдвийн хүрээнд эхийн үг болон авиа, гийгүүлэгчийн нийлэмжүүд, үгийн өргөлтийг зарим тохиолдолд дэмжлэггүйгээр зөв уншдаг</p>	<p>Судалсан “Routines” сэдвийн хүрээнд эхийн үг болон авиа, гийгүүлэгчийн нийлэмжүүд, үгийн өргөлтийг ихэнхдээ зөв уншдаг</p>	<p>Судалсан “Routines” сэдвийн хүрээнд эхийн үг болон авиа, гийгүүлэгчийн нийлэмжүүд, үгийн өргөлтийг зөв уншдаг</p>
<p><u>УНШИХ</u></p> <p>2. Судалсан танил сэдвийн хүрээнд энгийн эхийн хам сэдвээс гол ба туслах санаа, зохиогчийн хандлага, санаа бодлыг уншаад ялган таньдаг</p>	<p>Судалсан “Routines” сэдвийн хүрээнд, энгийн эхийн хам сэдвээс гол ба туслах санаа, зохиогчийн хандлага, санаа бодлыг бусдын дэмжлэгтэйгээр ялгадаг</p>	<p>Судалсан “Routines” сэдвийн хүрээнд энгийн эхийн хам сэдвээс гол ба зарим туслах санаа, зохиогчийн хандлага, санаа бодлыг ялган таньдаг</p>	<p>Судалсан “Routines” сэдвийн хүрээнд энгийн эхийн хам сэдвээс гол ба ихэнх туслах санаа болон зохиогчийн хандлага, санаа бодлыг ойлгодог</p>	<p>Судалсан “Routines” сэдвийн хүрээнд энгийн эхийн хам сэдвээс гол ба туслах санаа, зохиогчийн хандлага, санаа бодлыг бүрэн ойлгодог</p>
<p><u>БИЧИХ</u></p> <p>1. Судалсан танил сэдвийн хүрээнд үгсийг зөв бичдэг, цэг тэмдэгийг зориулалтын дагуу хэрэглэдэг</p>	<p>Судалсан “Routines” сэдвийн хүрээнд үгсийг дэмжлэгтэйгээр бичдэг цэг, таслал, асуултын тэмдэг, хашилт зэрэг цэг тэмдэгийг өгүүлбэрт таньж ялгадаг</p>	<p>Судалсан “Routines” сэдвийн хүрээнд үгсийг зарим тохиолдолд зөв бичдэг, цэг, таслал, асуултын тэмдэг, хашилт зэрэг цэг тэмдэгийг өгүүлбэрт ялган тэмдэглэдэг</p>	<p>Судалсан “Routines” сэдвийн хүрээнд ихэнх үгсийг зөв бичдэг, цэг, таслал, асуултын тэмдэг, хашилт зэрэг цэг тэмдэгийг өгүүлбэрт ихэнх тохиолдолд зөв ялган тэмдэглэдэг</p>	<p>Судалсан “Routines” сэдвийн хүрээнд үгсийг зөв бичдэг, цэг, таслал, асуултын тэмдэг, хашилт зэрэг цэг тэмдэгийг өгүүлбэрт зөв хэрэглэдэг</p>

<p>БИЧИХ</p> <p>2. Судалсан танил сэдвийн хүрээнд зэрэгцүүлэн холбох холбоосыг ашиглан энгийн нийлмэл өгүүлбэр бичдэг ба бичих зүйлээ төлөвлөдөг, хянадаг</p>	<p>Судалсан “Routines” сэдвийн хүрээнд ихэнх тохиолдолд энгийн, богино өгүүлбэр бичдэг</p>	<p>Судалсан “Routines” сэдвийн хүрээнд зэрэгцүүлэн холбох холбоос бүхий өгүүлбэр болон богино эхийг зарим тохиолдолд дэмжлэгтэйгээр бичдэг</p>	<p>Судалсан “Routines” сэдвийн хүрээнд зэрэгцүүлэн холбох холбоосыг ашиглан өгүүлбэрийг холбодог, богино эх зохион бичдэг</p>	<p>Судалсан “Routines” сэдвийн хүрээнд зэрэгцүүлэн холбох холбоосыг ашиглан энгийн нийлмэл өгүүлбэр ба богино эх зохион бичихдээ бичих зүйлээ бүрэн төлөвлөдөг, хянадаг</p>
<p>ХЭЛНИЙ ХЭРЭГЛЭЭ</p> <p>1. Судалсан танил сэдвийн хүрээнд хэлзүйн мэдлэгээ ярих болон бичихдээ ялган таньдаг</p>	<p>Судалсан “Routines” сэдвийн хүрээнд ярих болон бичихдээ холбогдох хэлзүйн дүрмийг дэмжлэгтэйгээр ялган таньдаг</p>	<p>Судалсан “Routines” сэдвийн хүрээнд ярих болон бичихдээ холбогдох хэлзүйн дүрмийг ялган таньж, зөв хэлбэрийг таньдаг</p>	<p>Судалсан “Routines” сэдвийн хүрээнд ярих болон бичихдээ холбогдох хэлзүйн дүрмийг ялган таньж, зохих хэлбэрийг зарим тохиолдолд ялган таньдаг</p>	<p>Судалсан “Routines” сэдвийн хүрээнд ярих болон бичихдээ холбогдох хэлзүйн дүрмийн хэлбэрийг зөв ялган таньдаг</p>
<p>ХЭЛНИЙ ХЭРЭГЛЭЭ</p> <p>2. Судалсан танил сэдвийн хүрээнд идэвхтэй үгийн нөөцийг аман болон бичгийн харилцаанд ашигладаг</p>	<p>Судалсан “Routines” сэдвийн хүрээнд идэвхтэй ба идэвхгүй үгийн хэрэглээг дэмжлэгтэйгээр таньж зарим тохиолдолд ашигладаг</p>	<p>Судалсан “Routines” сэдвийн хүрээнд зарим идэвхтэй үгийн хэрэглээг таньж ашигладаг</p>	<p>Судалсан “Routines” сэдвийн хүрээнд ихэнх идэвхтэй ба зарим идэвхгүй үгийн хэрэглээг таньж ашигладаг</p>	<p>Судалсан “Routines” сэдвийн хүрээнд бүх идэвхтэй ба ихэнх идэвхгүй үгийн хэрэглээг таньж ашигладаг</p>

1.3.5. XII ангийн “TEENS TODAY” сэдвийн үнэлгээний шалгуур

XII АНГИЙН “TEENS TODAY” НЭГЖИЙН СУРАЛЦАХУЙН ҮР ДҮН

XII ангийн нэгж хичээл дээр үнэлгээний нэгж дээр суурилсан суралцахуйн үр дүнг хэрхэн боловсруулж болох аргачлалыг харуулбал:

XII АНГИЙН “TEENS TODAY” СЭДВИЙН ҮНЭЛГЭЭ

Хүснэгт 9. XII ангийн “Teens today” сэдвийн үнэлгээний нэгжийн суралцахуйн үр дүнг тодорхойлсон аргачлал

Суралцахуйн зорилт	Үнэлгээний нэгж	Суралцахуйн үр дүн
12.L1 12.L2 12.L6	Сонсох	Сурагч нь “Teens today” сэдвийн хүрээнд өгүүлэгчийн дэлгэрэнгүй хүүрнэл болон ярианаас төрөл бүрийн утга санааг сонсоод ялган таньдаг ба ойлгосноо илэрхийлдэг болно.

12.S1 12.S6 12.S8	Ярих	Сурагч нь “Teens today” сэдвийн хүрээнд судалсан албан ба албан бус үг хэллэг, өгүүлбэрийн бүтцийг ашиглан өөрийн санаа үзэл бодлыг илэрхийлдэг, харилцдаг болно.
12.R1 12.R2 12.R6	Унших	Сурагч нь “Teens today” сэдвийн хүрээнд танил ба танил бус дэлгэрэнгүй эхээс төрөл бүрийн утга санааг ялган таньж ойлгодог болно.
12.W3	Бичих	Сурагч нь “Teens today” сэдвийн хүрээнд тохирох хэв маяг, албан ба албан бус үг хэллэг болон өгүүлбэрийн бүтцийг ашиглан өөрийн санаа, үзэл бодлыг илэрхийлэн найруулан бичдэг болно.
12.UЕ5 12.UЕ6 12.UЕ11	Хэлний хэрэглээ	Сурагч нь “Teens today” сэдвийн хүрээнд судалсан хэлзүйн хэрэглээний мэдлэгээ харилцан ярилцах, найруулан бичихдээ оновчтой ашигладаг болно.

1.3.6. XII ангийн “Teens today” нэгж сэдвийн үнэлгээний шалгуур

Хүснэгт 10. “Teens today” нэгж сэдвийн үнэлгээний нэгжийн суралцахуйн үр дүнгийн үнэлгээний шалгуурыг тодорхойлсон аргачлал

Үнэлгээний нэгж	Суралцахуйн үр дүн	Суралцахуйн үр дүнгийн үнэлгээний шалгуур
Сонсох	Сурагч нь “Teens today” сэдвийн хүрээнд өгүүлэгчийн дэлгэрэнгүй хүүрнэл болон ярианаас төрөл бүрийн утга санааг сонсоод ялган таньдаг ба ойлгосноо илэрхийлдэг болно.	Судалсан сэдвийн хүрээнд дэлгэрэнгүй хүүрнэл болон ярианаас гол, дагалдах, далд санаа болон өгүүлэгчийн санааг ялган таньдаг
		Судалсан сэдвийн хүрээнд дэлгэрэнгүй хүүрнэл болон яриаг сонсож ойлгосноо амаар болон бичгээр илэрхийлдэг
Ярих	Сурагч нь “Teens today” сэдвийн хүрээнд судалсан албан ба албан бус үг хэллэг, өгүүлбэрийн бүтцийг ашиглан өөрийн санаа үзэл бодлыг илэрхийлдэг, харилцдаг болно.	Судалсан сэдвийн хүрээнд баримтат ба баримтат бус үйл явдлын талаар ярихдаа тохирох албан ба албан бус хэл найруулгын үг хэллэг, өгүүлбэрийн бүтцийг ашигладаг
		Судалсан сэдвийн хүрээнд баримтат ба баримтат бус үйл явдлын талаар өөрийн үзэл бодлыг илэрхийлэх ба бусадтай санаа бодлоо хуваалцан харилцдаг
Унших	Сурагч нь “Teens today” сэдвийн хүрээнд танил ба танил бус дэлгэрэнгүй эхээс төрөл бүрийн утга санааг ялган таньж ойлгодог болно.	Судалсан сэдвийн хүрээнд дэлгэрэнгүй, баримтат ба баримтат бус, асуудал дэвшүүлсэн, зөрчилт санаа бүхий эхийн гол, дагалдах санаа болон зохиогчийн санаа бодлыг ялган таньдаг
		Судалсан сэдвийн хүрээнд дэлгэрэнгүй, баримтат ба баримтат бус, асуудал дэвшүүлсэн, зөрчилт санаа бүхий эхийг уншаад ойлгосноо амаар болон бичгээр илэрхийлдэг

Бичих	Сурагч нь “Teens today” сэдвийн хүрээнд тохирох хэв маяг, албан ба албан бус үг хэллэг болон өгүүлбэрийн бүтцийг ашиглан өөрийн санаа, үзэл бодлыг илэрхийлэн найруулан бичдэг болно.	Судалсан сэдвийн хүрээнд баримтат ба баримтат бус үйл явдлын талаар асуудал дэвшүүлсэн, зөрчилт санаа бүхий эхийг сэдэвт тохирсон загварын дагуу албан ба албан бус хэл найруулгын үг хэллэг, өгүүлбэрийн бүтцийг ашиглан бичдэг
		Судалсан сэдвийн хүрээнд баримтат ба баримтат бус үйл явдлын талаар асуудал дэвшүүлсэн, зөрчилт санаа бүхий эхийг загварын дагуу өөрийн санаа, үзэл бодлыг дэлгэрэнгүй найруулан бичдэг
Хэлний хэрэглээ	Сурагч нь “Teens today” сэдвийн хүрээнд судалсан хэлзүйн хэрэглээний мэдлэгээ харилцан ярилцах, найруулан бичихдээ оновчтой ашигладаг болно.	Судалсан сэдвийн хүрээнд хэлзүйн хэрэглээний мэдлэгээ танил ба танил бус нөхцөлд оновчтой ялган таньдаг
		Судалсан сэдвийн хүрээнд хэлзүйн хэрэглээний мэдлэгээ танил ба танил бус нөхцөлд харилцах болон бичихдээ оновчтой ашигладаг

Хүснэгт 11. **“TEENS TODAY”** нэгж сэдвийн жишээн дээр суралцахуйн үр дүнгийн шалгуурын гүйцэтгэлийн хүрэх түвшинг багцлан (I, II, III, IV) 4 түвшинд рубрикээр харуулав.

Суралцахуйн үр дүнгийн үнэлгээний шалгуур	ГҮЙЦЭТГЭЛИЙН ТҮВШИН			
	I	II	III	IV
<u>СОНСОХ</u> 1. Судалсан сэдвийн хүрээнд дэлгэрэнгүй хүүрнэл болон ярианаас гол, дагалдах, далд санаа болон өгүүлэгчийн санааг ялган таньдаг	Судалсан “Teens today” сэдвийн өргөн хүрээнд хүүрнэл, ярианаас гол, дагалдах санааг дэмжлэгтэйгээр таамаглан таньдаг	Судалсан “Teens today” сэдвийн өргөн хүрээнд хүүрнэл, ярианаас гол, дагалдах, далд санааг түлхүүр үгсийг ашиглан зөв таамаглан ялган таньдаг	Судалсан “Teens today” сэдвийн өргөн хүрээнд дэлгэрэнгүй хүүрнэл, ярианаас гол, дагалдах, далд санааг ихэнх тохиолдолд таамаглан ялган таньдаг	Судалсан “Teens today” сэдвийн өргөн хүрээнд дэлгэрэнгүй хүүрнэл, ярианаас гол, дагалдах, далд санаа болон өгүүлэгчийн санааг бүрэн таамаглан тодорхойлж ялган таньдаг
<u>СОНСОХ</u> 2. Судалсан сэдвийн хүрээнд дэлгэрэнгүй хүүрнэл болон яриаг сонсож ойлгосноо амаар болон бичгээр илэрхийлдэг	Судалсан “Teens today” сэдвийн өргөн хүрээнд дэлгэрэнгүй хүүрнэл болон яриан дахь мэдээллийг дэмжлэгтэйгээр боловсруулан ойлгосноо энгийн үг хэллэг, богино өгүүлбэрээр илэрхийлдэг	Судалсан “Teens today” сэдвийн өргөн хүрээнд дэлгэрэнгүй хүүрнэл болон яриан дахь мэдээллийг тодорхой хэмжээнд хүлээн авч боловсруулан ойлгосноо түлхүүр үг, богино болон энгийн өгүүлбэрээр илэрхийлдэг	Судалсан “Teens today” сэдвийн өргөн хүрээнд дэлгэрэнгүй хүүрнэл болон яриан дахь мэдээллийг хүлээн авч ойлгосноо яриа болон бичгээр тохирох үгийн нөөц, хэл зүйн мэдлэгээ ихэнх тохиолдолд зөв ашиглан илэрхийлдэг	Судалсан “Teens today” сэдвийн өргөн хүрээнд дэлгэрэнгүй хүүрнэл болон яриан дахь мэдээллийг хүлээн авч ойлгосноо яриа болон бичгээр тохирох үгийн нөөц, хэл зүйн мэдлэгээ ашиглан энгийн ба нийлмэл өгүүлбэрээр зөв илэрхийлдэг

<p><u>ЯРИХ</u></p> <p>Судалсан сэдвийн хүрээнд баримтат ба баримтат бус үйл явдлын талаар ярихдаа тохирох албан ба албан бус хэл найруулгын үг хэллэг, өгүүлбэрийн бүтцийг ашигладаг</p>	<p>Судалсан “Teens today” сэдвийн өргөн хүрээнд баримтат ба баримтат бус үйл явдлын талаар ярихдаа цөөн тооны албан бус үг хэллэг, энгийн өгүүлбэрийн бүтцийг ашигладаг</p>	<p>Судалсан “Teens today” сэдвийн өргөн хүрээнд баримтат ба баримтат бус үйл явдлын талаар ярихдаа тодорхой тооны албан ба албан бус үг хэллэг, энгийн өгүүлбэрийн бүтцийг ихэвчлэн ашигладаг</p>	<p>Судалсан “Teens today” сэдвийн өргөн хүрээнд баримтат ба баримтат бус үйл явдлын талаар ярихдаа албан ба албан бус хэл найруулгын зохих үг хэллэг, өгүүлбэрийн энгийн ба нийлмэл өгүүлбэрийн бүтцийг ихэнх тохиолдолд ашигладаг</p>	<p>Судалсан “Teens today” сэдвийн өргөн хүрээнд баримтат ба баримтат бус үйл явдлын талаар ярихдаа албан ба албан бус хэл найруулгын төрөл бүрийн үг хэллэг, энгийн ба нийлмэл өгүүлбэрийн бүтцийг зөв ашигладаг</p>
<p><u>ЯРИХ</u></p> <p>2.Судалсан сэдвийн хүрээнд баримтат ба баримтат бус үйл явдлын талаар өөрийн үзэл бодлыг илэрхийлэх ба бусадтай санаа бодлоо хуваалцан харилцдаг</p>	<p>Судалсан “Teens today” сэдвийн өргөн хүрээнд, баримтат ба баримтат бус үйл явдлын талаар өөрийн үзэл бодлыг дэмжлэгтэйгаар илэрхийлдэг ба бусдаас энгийн асуулт асуудаг, асуултад энгийн үг хэллэг, богино өгүүлбэрээр хариулдаг</p>	<p>Судалсан “Teens today” сэдвийн өргөн хүрээнд, баримтат ба баримтат бус үйл явдлын талаар өөрийн үзэл бодлыг тодорхой хэмжээнд илэрхийлж харилцах ба бусдаас асуулт асуудаг, асуултад энгийн өгүүлбэрээр гол төлөв хариулдаг</p>	<p>Судалсан “Teens today” сэдвийн өргөн хүрээнд, баримтат ба баримтат бус үйл явдлын талаар өөрийн үзэл бодлыг ихэнх тохиолдолд төвөггүй ярьж илэрхийлэх ба бусадтай харилцахдаа тохирох асуулт асуудаг, асуултад төвөггүй тодорхой хариулдаг</p>	<p>Судалсан “Teens today” сэдвийн өргөн хүрээнд, баримтат ба баримтат бус үйл явдлын талаар өөрийн үзэл бодлыг чөлөөтэй ярьж илэрхийлэх ба бусадтай харилцахдаа тэдний санааг нэгтгэн дүгнэн, санал дэвшүүлэн харилцдаг бусдаас оновчтой асуулт асуудаг, асуултад бүрэн хариулдаг</p>
<p><u>УНШИХ</u></p> <p>1.Судалсан сэдвийн хүрээнд дэлгэрэнгүй, баримтат ба баримтат бус, асуудал дэвшүүлсэн, зөрчилт санаа бүхий эхийн гол, дагалдах санаа болон зохиогчийн санаа бодлыг ялган таньдаг</p>	<p>Судалсан “Teens today” сэдвийн өргөн хүрээнд дэлгэрэнгүй, баримтат ба баримтат бус, асуудал дэвшүүлсэн, зөрчилт санаа бүхий эхийн гол, дагалдах санаа болон зохиогчийн санаа бодлыг дэмжлэгтэйгээр таньдаг</p>	<p>Судалсан “Teens today” сэдвийн өргөн хүрээнд дэлгэрэнгүй, баримтат ба баримтат бус, асуудал дэвшүүлсэн, зөрчилт санаа бүхий эхийн гол ба дагалдах санааг зарим тохиолдолд ялган таньдаг</p>	<p>Судалсан “Teens today” сэдвийн өргөн хүрээнд дэлгэрэнгүй, баримтат ба баримтат бус, асуудал дэвшүүлсэн, зөрчилт санаа бүхий эхийн гол, дагалдах санаа болон зохиогчийн санаа бодлыг ихэнх тохиолдолд зөв ялган таньдаг</p>	<p>Судалсан “Teens today” сэдвийн өргөн хүрээнд дэлгэрэнгүй, баримтат ба баримтат бус, асуудал дэвшүүлсэн, зөрчилт санаа бүхий эхийн гол, дагалдах санаа болон зохиогчийн санаа бодлыг бүрэн зөв ялган таньдаг</p>

<p><u>УНШИХ</u></p> <p>2. Судалсан сэдвийн хүрээнд дэлгэрэнгүй, баримтат ба баримтат бус, асуудал дэвшүүлсэн, зөрчилт санаа бүхий эхийг уншаад ойлгосноо амаар болон бичгээр илэрхийлдэг</p>	<p>Судалсан “Teens today” сэдвийн өргөн хүрээнд дэлгэрэнгүй, баримтат ба баримтат бус, асуудал дэвшүүлсэн, зөрчилт санаа бүхий эхийн утгыг хам сэдвээс дэмжлэгтэйгээр тааварлан уншиж ойлгон санаагаа амаар болон бичгээр илэрхийлэхийг оролддог</p>	<p>Судалсан “Teens today” сэдвийн өргөн хүрээнд дэлгэрэнгүй, баримтат ба баримтат бус, асуудал дэвшүүлсэн, зөрчилт санаа бүхий эхийн мэдээллийг боловсруулах ойлгосноо идэвхтэй үгийн нөөцөө ашиглан ихэвчлэн энгийн өгүүлбэрээр илэрхийлдэг</p>	<p>Судалсан “Teens today” сэдвийн өргөн хүрээнд дэлгэрэнгүй, баримтат ба баримтат бус, асуудал дэвшүүлсэн, зөрчилт санаа бүхий эхийн мэдээллийг уншиж ойлгон ойлгосноо яриа болон бичгээр тодорхой үгийн нөөц, хэл зүйн мэдлэгээ ашиглан ихэнх тохиолдолд энгийн ба нийлмэл өгүүлбэрээр илэрхийлдэг</p>	<p>Судалсан “Teens today” сэдвийн өргөн хүрээнд дэлгэрэнгүй, баримтат ба баримтат бус, асуудал дэвшүүлсэн, зөрчилт санаа бүхий эхийн мэдээллийг бүрэн уншиж ойлгон ойлгосноо яриа болон бичгээр тохирох үгийн нөөц, хэл зүйн мэдлэгээ ашиглан энгийн ба нийлмэл өгүүлбэрээр зөв илэрхийлдэг</p>
<p><u>БИЧИХ</u></p> <p>1. Судалсан сэдвийн хүрээнд баримтат ба баримтат бус үйл явдлын талаар асуудал дэвшүүлсэн, зөрчилт санаа бүхий эхийг сэдэвт тохирсон загварын дагуу албан ба албан бус хэл найруулгын үг хэллэг, өгүүлбэрийн бүтцийг ашиглан бичдэг</p>	<p>Судалсан “Teens today” сэдвийн өргөн хүрээнд баримтат ба баримтат бус үйл явдлын талаар сэдэвт тохирох үг хэллэг, хэл зүйн бүтцийг дэмжлэгтэйгээр хэрэглэн бичдэг</p>	<p>Судалсан “Teens today” сэдвийн өргөн хүрээнд баримтат ба баримтат бус үйл явдлын талаар эхийн сэдэвт тохирсон албан ба албан бус хэл найруулгын зарим үг хэллэг, хэл зүйн бүтцийг ашиглан бичихийг хичээдэг</p>	<p>Судалсан “Teens today” сэдвийн өргөн хүрээнд баримтат ба баримтат бус үйл явдлын талаар асуудал дэвшүүлсэн, зөрчилт санаа бүхий эхийн сэдэвт тохирсон албан ба албан бус хэл найруулгын үг хэллэг, хэл зүйн бүтцийг сонгож бичдэг</p>	<p>Судалсан “Teens today” сэдвийн өргөн хүрээнд баримтат ба баримтат бус үйл явдлын талаар асуудал дэвшүүлсэн, зөрчилт санаа бүхий эхийн сэдэвт тохирсон албан бус хэл найруулгын төрөл бүрийн үг хэллэг, өгүүлбэрийн бүтцийг ихэнх тохиолдолд оновчтой зөв сонгож бичдэг</p>

<p><u>БИЧИХ</u></p> <p>2.Судалсан сэдвийн хүрээнд баримтат ба баримтат бус үйл явдлын талаар асуудал дэвшүүлсэн, зөрчилт санаа бүхий эхийг загварын дагуу өөрийн санаа, үзэл бодлыг дэлгэрэнгүй найруулан бичдэг</p>	<p>Судалсан “Teens today” сэдвийн өргөн хүрээнд баримтат ба баримтат бус үйл явдлын талаар асуудал дэвшүүлсэн, зөрчилт санаа бүхий эх зохион өөрийн санаа, үзэл бодлыг илэрхийлэхдээ загварын дагуу өгөгдсөн агуулга, хэв маягт тохируулан өөрийн санаа, үзэл бодлыг илэрхийлэн бичихийг оролддог</p>	<p>Судалсан “Teens today” сэдвийн өргөн хүрээнд баримтат ба баримтат бус үйл явдлын талаар асуудал дэвшүүлсэн, зөрчилт санаа бүхий эх зохион өөрийн санаа, үзэл бодлыг илэрхийлэхдээ загварын дагуу өгөгдсөн агуулга, хэв маяг, үгийн тооны хэмжээнд тохируулан тодорхой дэс дараалалтай, найруулан бичихийг хичээдэг</p>	<p>Судалсан “Teens today” сэдвийн өргөн хүрээнд баримтат ба баримтат бус үйл явдлын талаар асуудал дэвшүүлсэн, зөрчилт санаа бүхий эх зохион өөрийн санаа, үзэл бодлыг илэрхийлэхдээ загварын дагуу өгөгдсөн агуулга, хэв маяг, үгийн тооны хэмжээнд тохируулан учир шалтгааны тодорхой дэс дараалалтай, найруулан бичдэг</p>	<p>Судалсан “Teens today” сэдвийн өргөн хүрээнд баримтат ба баримтат бус үйл явдлын талаар асуудал дэвшүүлсэн, зөрчилт санаа бүхий эх зохион өөрийн санаа, үзэл бодлыг илэрхийлэхдээ загварын дагуу өгөгдсөн агуулга, хэв маяг, үгийн тооны хэмжээнд тохируулан учир шалтгааны дэс дараалалтай, цэгцтэй дэлгэрэнгүй найруулан бичдэг</p>
<p><u>ХЭЛНИЙ ХЭРЭГЛЭЭ</u></p> <p>1.Судалсан сэдвийн хүрээнд хэлзүйн хэрэглээний мэдлэгээ танил ба танил бус нөхцөлд оновчтой ялган таньдаг</p>	<p>Судалсан “Teens today” сэдвийн өргөн хүрээнд харилцах болон бичихдээ хэлзүйн дүрмийг үгийн сан, үгзүй, өгүүлбэрзүй, эхийн түвшинд дэмжлэгтэйгээр ялгадаг</p>	<p>Судалсан “Teens today” сэдвийн өргөн хүрээнд харилцах болон бичихдээ хэлзүйн дүрмийг үгийн сан, үгзүй, өгүүлбэрзүй, эхийн түвшинд дэмжлэгтэй ба бага зэргийн дэмжлэгтэйгээр ялган таньдаг</p>	<p>Судалсан “Teens today” сэдвийн хүрээнд харилцах болон бичихдээ хэлзүйн дүрмийг үгийн сан, үгзүй, өгүүлбэрзүй, эхийн түвшинд зарим тохиолдолд оновчтой ялган таньдаг</p>	<p>Судалсан “Teens today” сэдвийн хүрээнд харилцах болон бичихдээ хэлзүйн дүрмийг үгийн сан, үгзүй, өгүүлбэрзүй, эхийн түвшинд ихэнх тохиолдолд зөв оновчтой ялган таньдаг</p>
